



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/03

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүгийн 2039004980004 дугаартай хэрэгт “Ойт бүс” ХХК-аас 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр экологи-эдийн засгийн үнэлгээ гаргасан зардал 4.132.700 /дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянга долоон зуун/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэгчээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнх-Эрдэнэ/-г аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр /хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар/ томилсугай.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний нэхэмжлэгчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

• 231010017